



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/508

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, дугаар зүйлийн 60.1.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.5, 14.7 дахь заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны Арвангуравдугаар Хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Хэрлэн сумын нутаг дэвсгэрт “Дулаан” нэртэй XV-23000081 бүртгэлийн дугаартай 35.40 гектар, “Дулаан” нэртэй XV-23000082 бүртгэлийн дугаартай 86.80 гектар талбайд “Нэмэх нэгдэл анд” ХХК-д түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгосугай.

2.Тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэрийг Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын зураг зүйн нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газар (Б.Дархантөр), Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), Цагдаагийн газар (Д.Батхүү), Хэрлэн сумын Засаг дарга (М.Шүрэнцэцэг)-д тус тус мэдэгдэж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т даалгасугай.

3.Хайгуулын ажлын төлөвлөгөөг хуулийн хугацаанд багтаан батлуулж, үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулах, холбогдох тайлан мэдээг цаг тухайд ирүүлж ажиллахыг “Нэмэх нэгдэл анд” ХХК-д зөвлөсүгэй.

4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг чанд мөрдүүлж, үйл ажиллагааны явцад хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), Цагдаагийн газар (Д.Батхүү), Байгаль, орчин аялал жуулчлалын газар (Б.Дархантөр)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ